



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

Энхтайваны өргөн чөлөө 7а,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: 26 21 35, Факс: (976-11) 32 21 27,
Цахим шуудан: info@mfa.gov.mn
Цахим хуудас: www.mfa.gov.mn

2024.11.28 № 09/5628.
таний -ны № -т

Г ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД
Б.ЧОЙЖИЛСҮРЭН ТАНАА

“Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн орчуулгыг баталгаажуулж, хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт:  хуудастай.



1142403412



**МОНГОЛ УЛСЫН УЛААНБААТАР ХОТЫН ДУЛААНЫ ГУРАВДУГААР
ЦАХИЛГААН СТАНЦЫН ӨРГӨТГӨЛ, ШИНЭЧЛЭЛИЙН ТӨСЛИЙН ЗУРАГ
ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар
(цаашид "Талууд" гэнэ) нь,

эрх тэгш, харилцан ашигтай, урт хугацааны стратегийн хамтын
ажиллагааны зарчимд тулгуурлан,

хоёр улсын найрсаг харилцааг бэхжүүлэх хүсэл эрмэлзэлээ баталж,

Талуудын улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил, Орос-Монголын эрчим
хүчиний салбарын харилцааг цаашид гүнзгийрүүлэх зорилгоор дараах асуудлаар
харилцан тохиролцов. Үүнд:

Нэгдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээр нь Монгол Улсын нутаг дэвсгэрт Улаанбаатар хотын
Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн зураг төсөл
(цаашид зураг төсөл, Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл,
шинэчлэл гэх)-ийг боловсруулах, түүн дотроо Дулааны гуравдугаар цахилгаан
станцын харьяа нутаг дэвсгэрт тохиролцсон хэмжээнд зураг төслийн ажил
гүйцэтгэх болон инженерчлэлийн судалгаа, шинжилгээ явуулах талуудын хамтын
ажиллагааны нехцелийг тодорхойлсон болно.

Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд Дулааны гуравдугаар цахилгаан өргөтгөл,
шинэчлэл гэдэг нь Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар
цахилгаан станцын өндөр даралтын хэсгийг 50 МВт (1x50 МВт) хүчин чадалтай
блокоор өргөтгэх, 48 МВт (4x12 МВт) хүчин чадалтай дунд даралтын хэсгийн
суурин дээр 250 МВт (2x125) блок барьж шинэчлэхийг ойлгоно.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЕСНЫ ОРЧУУЛГА МОНГ

Гарын үсэг /Signature:
Д.Б.

2024 оны // сарын 19-дээр

Улаанбаатар хот

Хоёрдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилтийг хангахын тулд Талууд дараах эрх бүхий байгууллагуудыг томилно. Үүнд:

Монголын талаас - Монгол Улсын Эрчим хучний яам;

Оросын талаас – Оросын Холбооны Улсын Эрчим хучний яам.

Эрх бүхий байгууллагыг солих тохиолдолд талууд дипломат шугамаар бие биедээ урьдчилан харилцан албан бичгээр мэдэгдэнэ.

Талуудын зураг төсөл боловсруулах эрх олгогдсон байгууллагууд нь:

Монголын талаас - захиалагчийн /цаашид захиалагч гэх/ чиг үүргийг Монгол Улсын Эрчим хучний яамны харьяа "Дулааны гуравдугаар цахилгаан станц" Төрийн өмчit хувьцаат компани хэрэгжүүлнэ.

Оросын талаас - "Интер РАО" Групп компанийн "ИНТЕР РАО-Экспорт" хязгаарлагдмал хариуцлагатай компани нь гүйцэтгэгчийн (цаашид гүйцэтгэгч гэх) чиг үүргийг хэрэгжүүлэх ба энэхүү Хэлэлцээрийн хүрээнд холбогдох байгууллагуудыг туслан гүйцэтгэгчидээр (цаашид туслан гүйцэтгэгчид гэх) татан оролцуулах эрхтэй байна;

Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд талуудын эрх бүхий байгууллагууд нь талуудын эрх олгогдсон байгууллагуудын хамтын ажиллагааг зохицуулах ба хэлэлцээрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавина.

Гуравдугаар зүйл

Талуудын эрх олгогдсон байгууллагууд Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн зураг төсөл боловсруулах нөхцөл, параметрүүдийг захиалагч, гүйцэтгэгч хооронд байгуулах гэрээнд тусгана.

Захиалагч, гүйцэтгэгч хооронд байгуулах Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн зураг төсөл боловсруулах гэрээ нь (цаашид зураг төслийн гэрээ гэх) ажил, үйлчилгээний тодорхой агуулга, үнэ, төлбөрийн нөхцөл, үүрэг биелүүлэх хугацаа, гүйцэтгэгч болон захиалагчийн хооронд хүлээсэн үүргийн нарийвчилсан хуваарилалт, тэдгээрийн хариуцлага зэргийг тодорхойлсон байна.

Талууд эрх олгогдсон байгууллагуудаар дамжуулан зураг төслийн гэрээнд Монгол Улсын хууль, тогтоомжийг мөрдлөг болгох ба 2016 оны Сингапурын Олон Улсын Арбитрын Төвийн (SIAC) арбитрын дүрмийн дагуу маргааныг шийдвэрлэх

Монгол Улсын Гадаад харилцааны нам
АЛБАН ЕСМНЫ ОРЧУУЛГА МӨН

Гэрлийн үсэг /Signature/ D.A.

2018 оны // сарын // өдөр

газраар Сингапур Улсад байрлах Сингапурын Олон Улсын Арбитрын Төвийг зааж өгнө.

Монгол Улсын хууль, тогтоомжид заасан худалдан авах ажиллагаа явуулахгүйгээр Монголын талын эрх олгогдсон байгууллага Оросын талын эрх олгогдсон байгууллагатай зураг төслийн гэрээг байгуулна.

Дөрөвдүгээр зүйл

Зураг төслийн гэрээг Монголын талаас эрх олгогдсон байгууллагын өөрийн хөрөнгөөр, эсхүл Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлнэ. Энэхүү зураг төслийн гэрээний санхүүжилтийг Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн гэрээ (цаашид өргөтгөл, шинэчлэлийн гэрээ гэх)-ний санхүүжилтэд оруулж тооцно.

Зураг төслийн боловсруулалтын үр дүнд гүйцэтгэгч болон захиалагч Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үнэ ба хэрэгжүүлэх боломжит хугацааг тодорхойлно. Энэ нь цаашид Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн санхүүжилтийн нөхцөл болон хэмжээг тодорхойлох болон Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн ханган нийлүүлэлт, ажил, үйлчилгээг санхүүжүүлэхийн (цаашид санхүүжүүлэлтийн хүсэлт гэх) тулд Монголын талаас Оросын талд Оросын Засгийн газрын экспортын зээлийг Монголын талд олгох хүсэлтийг илгээх зорилгоор хийгдэнэ.

Оросын талаас санхүүжүүлэлтийн хүсэлтийг зөвшөөрсөн нөхцөлд Талууд Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн ханган нийлүүлэлт, ажил, үйлчилгээг санхүүжүүлэх зорилгоор Монголын талд Оросын Засгийн газрын экспортын зээл олгох тухай болон Монгол улсын нутаг дэвсгэрт Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг тус тусад нь байгуулна.

Эдгээр хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах үүднээс Талуудын эрх олгогдсон байгууллагууд Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн гэрээг тусад нь байгуулна.

Тавдугаар зүйл

Зураг төсөл боловсруулах зорилгоор Монголын тал нь:

Зураг төсөл боловсруулахад шаардлагатай бүх төрлийн зөвшөөрлийн баримт бичгүүд, зөвшилцэл, тусгай зөвшөөрөл (шаардлагатай тохиолдолд) олгоход дэмжлэг үзүүлнэ.

Монгол Улсын Гадаад харилцааны мөн
АЛБАН ССЫН СОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг: Signature: *D.B.*

2024 оны // сарын // өдөр

Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийг хэрэгжүүлэх болон зураг төсөл боловсруулах хүрээнд ОХУ-ын эрх олгогдсон байгууллага, түүний Монгол Улсын нутаг дэвсгэр дэх төлөөлөгчийн газар (салбар) болон (эсвэл) охин компани, туслан гүйцэтгэгч, тэдгээрийн гэрээт гүйцэтгэгчид нарын ажилчдад Монгол Улсын нутаг дэвсгэрт саадгүй нэвтрэх, гарах, оршин суух, ажиллахад шаардлагатай бүх нөхцөлийг бурдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийг хэрэгжүүлэх болон зураг төсөл боловсруулахтай холбоотой бүх баримт бичгийг (гэрээ, зураг төсөл-шинжилгээ, судалгааны баримт бичиг) бэлтгэхэд орос, монгол болон англи хэлийг ашиглах ба орос хэлийг давуу хэл болгон баталгаажуулна.

Зураг төсөлтэй холбоотой ОХУ-ын норм, дүрэм, стандартуудын дагуу зураг төсөл боловсруулахыг баталгаажуулах ба энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдэж буй ОХУ-ын норм, дүрэм, стандартын дагуу ОХУ-аас үйлдвэрлэсэн, нийлүүлсэн;

Зураг төсөлд дараах тоног төхөөрөмжүүд болон материалууд ашиглахыг баталгаажуулна.

- энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдэж буй ОХУ-ын норм, дүрэм, стандартын дагуу ОХУ-аас үйлдвэрлэсэн, нийлүүлсэн;

- энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдэж буй гуравдагч улсын норм, дүрэм, стандартын дагуу гуравдагч улсаас үйлдвэрлэсэн, нийлүүлсэн;

ОХУ-ын эрх олгогдсон байгууллагад одоо байгаа тоног төхөөрөмж, инженерийн шугам сүлжээ, геодезийн (лавлагаа) цэг болон зураг төслийг боловсруулахад шаардлагатай бусад мэдээллийг цуглуулан бэлтгэж, гаргаж өгөх.

Зургаадугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрт заасан хамтын ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд Оросын талын эрх олгогдсон байгууллага дараах үйл ажиллагааны хэрэгжилтийг хангана.

1) зураг төслийн гэрээнд гарын үсэг зурахаас өмч:

Монгол Улсын Гадаад харилцааны яв
АЛБАН СОНГОГЧИЙН НАМ

Гарын үсэг /Signature/ D.B.

2022.06.11. 17:19:19

захиалагчтай тохиролцсон техникийн үндсэн шийдэлд үндэслэн зураг боловсруулах гэрээний техникийн ажлын даалгавар болон техник-арилжааны саналыг бэлтгэх;

2) Зураг төслийн гэрээнд гарын үсэг зурсаны дараа түүний нэхцэлийн дагуу:

Монголын талын гүйцэтгэсэн барилгын талбайн инженерийн анхан шатны судалгааны үр дүнд ханган нийлүүлэлтийн үзүүлэлт, ажлын цар хүрээг тодорхойлох зорилгоор ОХУ-ын хууль, тогтоомжийн дагуу ОХУ-ын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн баталгаат тоног төхөөрөмж дээр сууринсан Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн зураг тесэл боловсруулах;

Гүйцэтгэгч нь зураг тесэл боловсруулахын тулд Оросын болон Монголын зураг төслийн байгууллагаыг туслан гүйцэтгэгчээр татан оролцуулах;

Оросын талын экспертизийн байгууллагаар зураг төслийн баримт бичгийн хараат бус шалгалтыг зохион байгуулах;

Захиалагч нь зураг төслийн хүрээнд Монгол Улсын хууль, тогтоомжийн дагуу шаардагдах зураг төслийн баримт бичгийн экспертизийн дүгнэлт хийх зөвшөөрөл авахад мэргэжлийн туслалцаа үзүүлэх;

Өргөтгөл, шинэчлэлийн гэрээний дагуу ханган нийлүүлэлт, ажил, үйлчилгээ, үндсэн болон туслах тоноглолын нарийвчилсан зургийн /ажлын баримт бичиг/ үр дүнгээр Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн төсвийг тодорхойлох;

Зураг төслийн гэрээний хүрээнд гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч болон тэдгээрийн гүйцэтгэгч нарын ажилчдыг Монгол Улсад томилолтоор ажиллуулах.

Долдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрт заасан хамтын ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор Монголын талын эрх олгогдсон байгууллага дараах үйл ажиллагааны хэрэгжилтийг хангана. Үүнд:

1) зураг төслийн гэрээнд гарын үсэг зурахаас өмнө:

Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн зураг тесэл боловсруулахад шаардлагатай анхдагч өгөгдлүүдийг гүйцэтгэгч талтай тохиролцсон хэмжээ болон хугацаанд гаргаж өгөх;

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЕСНҮҮ ОРЧНУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature ...

Р.Б.

2021 оны 11 сарын 19-ний

Есдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрийг хэрэглэх болон (эсвэл) тайлбарлахтай холбоотой Талууд хоорондын маргааныг Талуудын эрх бүхий байгууллагууд зөвшилцэх, хэлэлцээ хийх замаар шийдвэрлэнэ.

Хэрэв эдгээр маргаан, санал зөрөлдөөнийг Талуудын эрх бүхий байгууллага хооронд зөвшилцэх замаар шийдвэрлэх боломжгүй бол Талууд найрсаг хэлэлцээгээр шийдвэрлэнэ.

Аравдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлтийг Талуудын бичгээр өгсөн зөвшөөрлөөр үйлдэх бөгөөд тухай бүр тэмдэглэл үйлдэнэ.

Арван нэгдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээр нь түүнийг хучин төгөлдөр болгсод шаардлагатай засгийн газрын дотоод үйл ажиллагааг Талууд биелүүлсэн талаарх мэдэгдлийг дипломат шугамаар хамгийн сүүлийн бичгээр хүлээн авсан өдрөөс эхлэн хучин төгөлдөр болно.

Гүйцэтгэгч нь энэхүү Хэлэлцээрийн дөрөвдүгээр зүйлд заасан Засгийн газар хоорондын тусдаа хэлэлцээрийн хүрээнд Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгэл, шинэчлэлийг хийж дууссаны дараа энэхүү Хэлэлцээр дуусгавар болно. Талууд энэхүү Хэлэлцээрийг цуцлах өдрийг дипломат шугамаар нот бичиг солилцох замаар тогтооно.

Хэлэлцээрийг Чиландагтар хотноо 2024 оны 9 дундаж сарын 3-ны өдөр тус бурийг нь монгол, орос хэлээр хоёр хувь үйлдсэн ба хувь тус бүр нь адил хүчинтэй байна.

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

Монгол Улсын Головад Харилцааны яам
Альянс ФСМРТ ОРИЧУУЛГА МЭН

Гарын үсэг /Signature/

2024 оны 9 сарын 3 өдөр

Уланбаатар хот